

Гарчиг

БҮЛЭГ I: ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн өрөнхий мэдээлэл	3
1.2 Төслийн товч танилцуулга	4
1.3 Ил уурхай.....	5
1.3.1. Ашиглалтын системийн элементүүд	5
1.3.2. Уурхайн хүчин чадал ба ажиллах горим.....	5
1.3.3. Ил уурхайн хөрс хуулалт ба овоолгын ажлын	5
1.4 Ус ашиглалт.....	6
1.5 Гадаад тээвэрлэлт.....	6
1.6 Барилга байгууламж, дэд бүтэц.....	6
БҮЛЭГ II: ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ	8
ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	8
2.2 Газрын гадарга, хэвлэй, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл	8
2.3 Ургамлан бүрхэвч, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	9
2.4 Усан орчин, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	9
2.5 Амьтны аймаг, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	9
2.6 Нийгэм эдийн засагт учруулах нөлөөлөл	9
БҮЛЭГ III: БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН	11
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	11
БҮЛЭГ IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
БҮЛЭГ V. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5.1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө.....	14
БҮЛЭГ VI. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
БҮЛЭГ VII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА.....	15
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
БҮЛЭГ VIII. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	15
ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15

БҮЛЭГ IX. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ X. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ XI. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	18
БҮЛЭГ XII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ.....	19
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	19
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ....	19
ЗАРДАЛ.....	19

Хүснэгт

Хүснэгт 1. Ил уурхайн олборлолтонд өртөх талбай.....	5
Хүснэгт 2. Уурхайн олборлолтонд өртөх талбай.....	5
Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалт	6
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	16
Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалт	17
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
Хүснэгт 9. Нийт зардал	19

БҮЛЭГ I: ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “АДАЭ” ХХК /УБД: 9019059072, РД: 5098564/

Төслийн нэр: “Булаг” хайлуур жоншны орд ашиглах төсөл

Төслийн зорилго: Уул уурхайн үйлдвэрлэл хэрэгжүүлж жонш олборлох

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020796

Төсөл хэрэгжих талбайн байршил: “Булаг” хайлуур жоншны орд ашиглах төслийн талбай нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт оршдог бөгөөд MV-020796A дугаартай уул уурхайн үйлдвэрлэл, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд байрладаг. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 800 км, Баруун-урт хотоос 220 км, Эрдэнэцагаан сумын төвөөс урагш 25 км зайд байрлана.



Тусгай зөвшөөрлийн талбайн координат	
Өргөрөг	Өргөрөг
115° 22' 0"	45° 42' 5"
115° 22' 0"	45° 41' 40"
115° 22' 30"	45° 41' 40"
115° 22' 30"	45° 40' 40"
115° 20' 30"	45° 40' 40"
115° 20' 30"	45° 42' 5"
115° 22' 0"	45° 42' 5"
115° 22' 0"	45° 41' 40"



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.2 Төслийн товч танилцуулга

“АДАЭ” ХХК нь MV-020796 талбайд хайлуур жоншны уурхай, жонш баяжуулах үйлдвэр ашиглалтад оруулахаар 2019 онд төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн.

“АДАЭ”ХХК нь уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрийн барилгын ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөсөн боловч Дэлхий нийтийн хамарсан ковид-19 цар тахлын улмаас хөрөнгө оруулалтын ажил тодорхой хугацаанд хойшлогдсон. Төслийн талбайд одоогоор хөрс хуулалт болон барилга байгууламж барих ажил эхлээгүй байгаа ба 2024 оноос эхлэх уурхайн бэлтгэл ажлууд хийгдэж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.

Уг төсөл нь нийт 6 жилийн хугацаанд хэрэгжих ба цаашид нөөцийн судалгааг дахин явуулж нөөцийн хэмжээг тодорхойлуулан үргэлжлэх бүрэн боломжтой. Төслийн талбайд баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж эцсийн бүтээгдэхүүнийг Хятад улсад экспортолно. Төслийн талбай нь далд уурхайн хэсэг, шимт хөрсний овоолго, гадаад овоолго, ажилчдын кемп, оффис, баяжуулах үйлдвэр, тэсрэх материалын агуулах, засварын газар, ШТС, зам талбай зэргээс бүрдэнэ.

2024 онд төслийн анхны жилд хийгдэхээр төлөвлөгдсөн ил уурхайн олборлолт баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт, бэлтгэл малталтын ажил тус тус хийгдэх юм.

2024 онд 910.7 мян.м3 хөрс хуулж 97.1 мян.тн хүдэр олборлоно. Далд уурхайн бэлтгэл малталт нийт 248.5 мян.м3 ажил хийгдэнэ. Баяжуулах үйлдвэр нь уурхайн хүчин чадалтай уялдаж, уурхай бүрэн хүчин чадлаар ажиллах үеийн жилийн хүчин чадал болох 45000 тн хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр байна.

Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт уурхай ашиглалтын 2 дох жилээс эхэлнэ.

1.3 Ил уурхай

1.3.1. Ашиглалтын системийн элементүүд

Доголын өндөр. Ажлын (ашиглалтын) даголын чухал элемент болох өндрийн хэмжээг тогтооход олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд тухайн тохиолдолд уурхайн хүчин чадал бага, уурхайд ажиллах техникийн ажиллах оновчой хэмжээс зэргээс хамаарч даголын өндрийг оновчлов. Уурхайн ажлын даголын өндрийг $H_d=5$ м байхаар тооцов. Харин ажлын дагол нь ажлын бус бүсэд шилжихэд хоёр даголыг нэгтгэн хурааж ажлын бус дагол үүсгэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3.2. Уурхайн хүчин чадал ба ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас саатах, ээлжит засвар үйлчилгээ, зөөвөр нүүдэл зэрэг хүчин зүйлүүдийг тооцон

- Жилийн нийт ажиллах хоног - 180
 - Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зарцуулах хоног - 2
 - Цаг уур, нүүдэл, сэлбэгийн хангамжийн saatlaas сул зогсох хоног -8
- Уурхайн цэвэр ажиллах хоног: $180 - 2 - 8 = 170$ хоног
- Хоногт ажиллах ээлж – 2
 - Ээлжийн үргэлжлэх хугацаа- 12 цаг

1.3.3. Ил уурхайн хөрс хуулалт ба овоолгын ажлын

Хүснэгт 1. Ил уурхайн олборлолтонд өртөх талбай

Уурхай	Ашиглалтаар үүсэх карьериийн хэмжээ			Эвдрэлд өртөх талбай, м ²
	Үрт, м	Өргөн, м	Гүн, м	
1 - р уурхай	370	100	40	36400

Хүснэгт 2. Уурхайн олборлолтонд өртөх талбай

Уурхай		Гадаад овоолго		Технологийн зам		Шимт хөрс		Хотхон		Далан	
² м	га	² м	га	² м	га	² м	га	² м	га	² м	га
60,630	6.063	79,394	7.94	130	0.01	2,892	0.29	10,000	1	6,807	0.68
Нийт эвдрэлд өртөх талбайн хэмжээ /га/						15.98					

1.4 Ус ашиглалт

Булаг хайлуур жоншны орд ашиглах төсөл нь баяжуулах үйлдвэрийн технологи, далд уурхайн өрөм, бэхэлгээ шүрших үед, баяжуулах үйлдвэрийн дэргэдэх лаборатори, унд ахуйд, зам талбай ногоон байгууламж услах зориулалтаар ус ашиглана. Төслийн ус ашиглалтыг гүний 2 худгаас болон далд уурхайн шүүрлийн усаар хангана.

Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалт

ДД	Үзүүлэлт	Ашиглалтын жил						Нийт
		1	2	3	4	5	6	
5	Унд, ахуйн хэрэглээ, м ³	420	1260	1260	1260	1260	1260	6720
6	Замын усалгаа, мян.м ³	13.5	40.5	40.5	40.5	40.5	40.5	216
Нийт		22398	65880	65880	65880	65880	65880	351798

1.5 Гадаад тээвэрлэлт

Баяжмал бүтээгдэхүүнийг Бичигтийн хилийн боомт хүртэл 70 км зайд тээвэрлэнэ. Бичигтийн боомт руу сайжруулсан шороон замаар Өгөөмөрийн нүүрсний уурхай, Сайн хөөвөр, Бадмаараг хаш, Баянцогт, Төхөмийн нүүрсний уурхай, Цайрт минералын уурхай зэрэг ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд тээвэрлэлт хийж байна.

“АДАЭ”ХХК нь энэхүү тээвэрлэлтийн зам хүртэл 35 км сайжруулсан шороон зам тавихаар төлөвлөсөн ба эхний жил далд уурхайн бэлтгэл, баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг төлөвлөсөн.

1.6 Барилга байгууламж, дэд бүтэц

Булаг төсөл нь одоогийн байдлаар хөрөнгө оруулалтын шатандаа явж байгаа бөгөөд төслийн хугацаанд үйлдвэрлэлийн барилга байгууламжуудыг барьж ашиглах бөгөөд эдгээр барилгууд нь зориулалтаасаа хамаарч сэндвичэн болон контейнерэн байгууламжууд байна. Төслийн хүрээнд баяжуулах үйлдвэр, засварын цех, уурын зуух, ажилчдын амрах байр, оффис, тэсрэх бодисын агуулах, шатах тослох материалын агуулах ШТС, сэлбэг хэрэгслийн агуулах, хамгаалалтын хашаа, пост, далд уурхайн үйлдвэрлэлийн барилгууд зэрэг барилга байгууламжуудыг бий болгоно.

АДЭА ХХК, БУЛАГ НЭРТЭЙ MV-020796 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Цахилгаан хангамж: Эрдэнэцагаан сумын төв нь 35 кВт-ын шугамд холбогдсон бөгөөд сумын төвөөс 25 км өндөр хүчдлийн шугам татаж төслийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэх боломжтой. Төслийн цахилгаан хэрэглэгчид нь үндсэн шугамаас татах 6 кВ-ын өндөр хүчдэлийн 25 км-ийн урттай шугамд холбогдох уурхайн дэргэдэх 6/0.4 кВ-ын бууруулах трансформаторын дэд станцаас тэжээгдэнэ.

Дулаан хангамж: Дулаан хангамж халаалтын системийг шийдэхдээ DZL маркийн нам даралтын зуух хэрэглэдэг.

БҮЛЭГ II: ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Булаг” хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бүрэлдэхүүн тус бүрээр товч байдлаар тодорхойлов. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Барилга байгууламж барих, далд уурхайн олборлолтын өмнөх бүтээн байгуулалт, зам талбай засах хөрс хуулах, хөрс, хүдэр тээвэрлэх гэх мэт үйл ажиллагааны үед тоосжилт үүснэ.
- Уурхай дахь тээврийн хэрэгсэл болон автомашины хөдөлгүүрийн дутуу шаталтын хий нь агаар орчныг хорт хийгээр бохирдуулж болзошгүй.
- Барилга байгууламж барих, уурхайн олборлолтоос үүдэн чичиргээ доргио, дуу шуугианы бохирдлыг үүсгэж болзошгүй.
- Тоосжилт, хорт хийн ялгаралт, тэсэлгээнээс үүдэх дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны айл өрхийн амгалан тайван байдал алдагдаж, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

2.2 Газрын гадарга, хэвлэй, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Уурхайн олборлолт, тэсэлгээ явуулах, хаягдал болон хүдэр буулгах талбай засах, тээвэрлэлтийн зам засах, холбогдох барилга байгууламж барих зэргээр газрын гадарга, хэвлэйд нөлөөлнө.
- Баяжуулах үйлдвэрлэлийн болон оффис, ахуйн барилга байгууламж, дотоод тээвэрлэлтийн зам зэрэг уул уурхайн нөлөөгөөр газрын гадаргын өнгөн хэсэг эвдрэлд өртөнө.
- Төслийн ТЭЗҮ-д тусгагдаагүй талбайд суваг, шуудуу татах, нүх ухах, барилга байгууламж нэмэлтээр барих, далан байгуулах зэргээр газрын гадарга, хэвлэй эвдрэх талбай нэмэгдэж болзошгүй.
- Хүнд, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрс суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.
- Нефтийн гаралтай материал, тэсрэх бодисын асгаралт, шүүрэлт мөн үйлдвэрлэлийн болон, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүснэ.

2.3 Ургамлан бүрхэвч, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь уурхайн олборлолтын үйл ажиллагаа, далд уурхайн ам нээх, дотоод болон гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцор, төслийн бүхий л барилга байгууламжууд, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал, хүн, техникийн нөлөөгөөр ургамлан нөмрөг устах буюу доройтолд орно.

2.4 Усан орчин, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Ордын хайгуулын өрөмдлөгийн явцад уст үе тэмдэглэгдээгүй тул уг жоншны ордыг агуулагч хурдас усжилт багатай гэж үзэж болох хэдий ч далд уурхайн ашиглалтын үед түр зуурын харьцангуй өндөр хэмжээтэй орох ус хагарал, ан цавын систем хөндөгдсөн үед гарч болох талтай юм.
- Далд уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр гүний ус бохирдож болзошгүй.
- Баяжуулах үйлдвэрт технологийн хэрэгцээнд гүний ус ашиглах тул гүний усны нөөцөд нөлөөлнө.

2.5 Амьтны аймаг, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- “Булаг”хайлуур жоншны орд орчмын амьтдын амьдрах орчин, экологид олборлолтын машин техникийн хөдөлгөөн, дуу чимээ, барилга байгууламжийн байршуулалт, генераторын дуу чимээ, ашигт малтмалын зөөвөрлөлт, тээвэрлэлт, далд уурхайн тэсэлгээнээс үүсэх дуу чимээ, доргилт ихээхэн нөлөө үзүүлнэ.
- Техникуудийн шатахуун болон тосны үнэр зэрэг нь техногенийн шинжтэй ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэгээс эдгээр амьтад дайжих замаар байршил нутгаа өөрчлөх, үүрлэж төллөдөг газруудаа өөрчлөх, байнгын стресст орох, идэш тэжээлээ эрж олох зэрэг амьдралын олон үйл ажиллагаанд нь өөрчлөлт орно.

2.6 Нийгэм эдийн засагт учруулах нөлөөлөл

- Уурхайн үйл ажиллагаанаас бий болох дуу чимээ, шороо тоос, хүн, машин техникийн хөдөлгөнөөс болж орон нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдал алдагдаж болзошгүй.
- Бэлчээрийн хомсдол үүсэх.

- Орон нутгийн ард иргэд төсөлтэй холбоотой янз бүрийн санал, гомдол, эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй.
- Төслийн татвар хураамжаар орон нутгийн орлого нэмэгдэх бөгөөд үүний үр дүнд тухайн орон нутгийн нийгмийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт болно. Уурхайн үйл ажиллагаа эхэлснээр ажлын байр нэмэгдэж, малчид болон орон нутгийн хувиараа бизнес эрхлэгчид хамтран ажиллах боломжтой.

БҮЛЭГ III: БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Ашиглалтын эхний жил ил уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт хийгдэж 2дох жилээс уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллахаар төлөвлөсөн.

2024 онд далд уурхайн бэлтгэл ажил, баяжуулах үйлдвэр, ажилчдын амрах байр тосгоны бүтээн байгуулалт зэрэг ажлууд хийгдэх тул барилга байгууламж барих үеэс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ зэргийг төлөвлөж хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг тооцож тусгав.

“АДАЭ” ХХК нь уурхайн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн хэсэг болох ус, ургамал, агаар, амьтан, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөллийн бүсэд орших айл өрх, орон нутагт ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

БҮЛЭГ IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүл эх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1 АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ							
	Уурхай, үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед гарч болох тоосжилт, хорт хий үүсэх эх үүсвэрүүд: - Шимт хөрс хуулах - Суваг шуудуу татах - Техник хэрэгсэлийн хөдөлгөөний үед тоосжилт үүсэх - Барилгын материал, тоног төхөөрөмж тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Уурхайн барилга байгууламжийн бүтээн байгуулалт, шимт хөрс хуулалтын үед үүсэх тоосжилтыг бууруулах усалгаа хийх.	Үйл ажиллагааны турш	-	Үйл ажиллагааны зардалд	Сар улирлаар	БОС-ын 1995 оны 153 тоот тушаал
		Төслийн талбай дахь зам, машин паркын талбайг тоосжилт үүсэхээс сэргийлж хайрган болон хатуу хучилт хийх.	Үйл ажиллагааны турш	200,0	800,0	2024 он	Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Тээврийн машин механизмуудын янданд шүүлтүүр тавих	Үйл ажиллагааны турш	58,0	15x 58,0= 870.0	2024 он	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
	Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Ажиллагсадад тоосноос хамгаалах хушуувч, амны маск зэрэг XXX ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах	Үйл ажиллагааны турш	ХХАА-ны зардалд	ХХАА-ны зардалд	2024 он	MNS(ISO)13688:2000 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
	Нийт дүн				1670.0		
2.ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ							
	Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал,	Уурхай, барилга байгууламжийн бүтээн байгуулалтын эхэн үед шимт хөрсийг хуулан авч овоолго хийн хадгалах	Төслийн эхэн үе шатанд	-	Үйл ажиллагааны зардалд	2024 он	MNS 5915:2008
		Уурхай болон үйлдвэрийн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	200,0	1000,0	Жил бүр	-
		ШТМ-ыг хадгалах стандартын шаардлага, талбай, агуулах байгуулах	Төслийн эхэн үе шатанд	-	800,0	2024 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрсний

**АДЭА ХХК, БУЛАГ НЭРТЭЙ MV-020796 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэх	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд хатуу хучилт хийх	Төслийн эхэн үе шатанд	Барилгын ажлын зардал	2024 он	химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
		Нийт дүн		1800.0	

3. УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдагдуулснаар	Ахуйн бохир ус цэвэршүүлэн зайлуулах, септик танк байгуулах	Төслийн эхэн үе	Кэмп байгуулалт, хөрөнгө оруулалтын зардал	Кэмп байгуулалт, хөрөнгө оруулалтын зардал	2024 он	
газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтад сэргээр нөлөөлж болзошгүй.	Төслийн үйл ажиллагаанд ашиглах гүний худгийг тохижуулах, тоолууржуулах, эрүүл ахуйн бүс тогтоох	Төслийн эхэн үе	1500,0	1500,0	2024 он	
	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ	ҮАЗ	-	
Нийт дүн			1500.0			
НИЙТ ДҮН			4,970.00			

БҮЛЭГ V. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“АДАЭ”ХХК нь 2024 онд ил уурхайн ашиглалт явуулах, далд уурхайн олборлолтын бэлтгэл хангах, барилга байгууламж барих, зам талбай засах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөсөн тул 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө тусгагдаагүй.

Төслийн ТЭЗҮ, БОННҮ-д техникийн нөхөн сэргээлтийг төслийн 4 дэх жилээс биологийн нөхөн сэргээлтийг төслийн 5 дах жилээс эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

5.1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө.

Тус төсөл ашиглалтын анхны жил тул хөрөнгө оруулалт, уурхайн байгуулалтын ажлууд түлхүү хийгдэх юм. 2024 оны төлөвлөгөөнд тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын саналыг үндэслэн тус сумын төгөлд 500 ш мод тарьж ургуулахаар төлөвлөв. Зардал 2024 онд 10,500.00 мян.төг.

БҮЛЭГ VI. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байdag.

“АДАЭ”ХХК нь 2024 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргахдаа орон нутгийн байгаль орчны газраас санал авсан болно.

Сүхбаатар аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн 255 тоот дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний саналын дагуу дараах ажлыг төлөвлөсөн болно. /албан бичгийг хавсаргав/

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалалтын арга хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх газар, хугацаа	Баримтлах стандарт,
Орон нутгийн байгаль орчны газрын санал	Онгон, Баяндэлгэр сумдын нутаг дахь Онгон таван булаг нэрээр байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах	3500	2024 он	
Орон нутгийн байгаль орчны газрын санал	Хонхор цантын нүхт нэртэй газарт нөхөн сэргээлт хаалт хамгаалалтын ажил гүйцэтгэнэ.	4000	2024 он	
Нийт зардал		7 500.0		

БҮЛЭГ VII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд айл өрх, өвөлжөө, хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

БҮЛЭГ VIII. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“АДАЭ” ХХК-ийн Булагийн ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палентологийн хүрээлэнгийн судлаачдаар авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтанд ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлыг зогсоож

АДЭА ХХК, БУЛАГ НЭРТЭЙ МВ-020796 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БУХИЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Эрдэнэцагаан сумын ЗДТГ, Цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

БҮЛЭГ IX. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал жилдээ 2 650.0 мян.төгрөг байхаар тооцоо гарч байна. Дэлгэрэнгүй задаргааг доорх хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ Эрдэнэцагаан сумын засаг даргаар тогтоолгоно.	-	ААН-ын захиргаа, санхүү	Эрдэнэцагаан сумын засаг даргын захирамж байна.
2	Хог хаягдлын төлбөрөө төлнө.	-		Төлбөр төлсөн баримт. Үйл ажиллагааны зардалд орно
3	Хэлтэс нэгжүүдэд хатуу хаягдал ангилан ялгах сав байрлуулна.	500. 0	Уурхайн дарга Байгаль орчны мэргэжилтэн	Жил бүр хог савны бүтэн байдлыг шалгаж, солих
4	Аюултай хатуу хог хаягдал, ашигласан тос масло түр хадгалах цэг байгуулж орчны бохирдооос сэргийлж цементжүүлэх, хашаажуулах, хаягжуулах	800.0		Хур борооны усаар дамжин хөрс, усан орчин бохирдооос сэргийлнэ.
5	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг эрх бүхий байгууллагад шилжүүлж байх	-	Уурхайн дарга Байгаль орчны мэргэжилтэн	Хог хаягдлын бүртгэл хийж байна.
6	Үйлдвэрээс гарах дахин ашиглах боломжтой хог хаягдлын цэгийг тусд нь байгуулж тохижуулах.	330.0		Барилгын болон үйлдвэрийн дахин ашиглах боломжтой хаягдлыг дахин ашиглах
7	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдвартгүйжүүлэлт хийлгэх.	500.0		Жилд нэг удаа хийлгэх
8	Дахин ашиглагдахгүй хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх.	Үйл ажиллагааны зардалд		Орон нутагтай хамтран ажиллах
	Нийт зардал			2130.0

БҮЛЭГ Х. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалт

1	БОННҮ тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаанд даа тусгаж хэрэгжүүлэх.	Төсөл хэрэгжих хугацаанд	-	Компанийн захиргаа
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гол түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, семинар ажилчдын дунд зохион байгуулж байгаль орчны мэдлэг олгох. Холбогдох байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан хамтран ажиллах.	2024 он	500.0	Компанийн захиргаа ХАБ Байгаль орчны мэргэжилтэн
3	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах.	2024 он	1500.0	Компанийн захиргаа ХАБ
4	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвөлгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах.	Төсөл хэрэгжих хугацаанд	-	Компанийн захиргаа
Нийт зардал			2000.0	

БҮЛЭГ XI. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

1	Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , CO-ын агууламж, Хүнд металл тодорхойлох Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ	Агаарын шинжилгээг жилд 2 удаа 3 цэгт хийнэ. 400.0	Жилд 2 удаа	Уурхайн ажилчдын хотхон, уурхайн зам	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007
2	Ус	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ, (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, цахилгаан дамжуулах чанар)	Хаягдал бохир усны цэг болон ундны усны 2 цэгт жилд 2 удаа дээжлэлт авч шинжлүүлнэ. 92.0	Жилд 2 удаа	Ундны ус 2, хаягдал бохир уснаас 2	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд,
3	Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	Хөрсний хяналт шинжилгээний 5 цэгт жилд 1 удаа 130.0	Жилд 2 удаа	Уурхай, ахуйн бохир усны хаягдал орчим, хатуу хаягдлын цэг	MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл, MNS 331091 Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
Нийт		1 100.0				

**БҮЛЭГ XII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 тоот тогтоолын дагуу Олборлох үйлдвэрийн ил тод байдлын талаар нийтэд мэдээллэж байх тогтоолын дагуу “АДАЭ”ХХК нь үйл ажиллагаа, БОМТ-ний хийгдэж байгаа ажлуудаа орон нутгийн удирдлага, иргэдэд 11 дугаар сард танилцуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөв.

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ
ЗАРДАЛ**

Хүснэгт 9. Нийт зардал

№	Зардлын утга	Зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4 970.0
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	10 500.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	7 500.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	2 130.0
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	2 000.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг гүйцэтгэх зардал	1 000.0
	Нийт зардал	28 200.0

2024 оны БОМТ-ий нийт зардал **28 200 000 төгрөг** болж байна. Үүний 50% буюу **14 1000 000 төгрөгийг** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалт, Байгаль орчны ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан болно.

Эрх зүйн орчин

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Булаг” хайлуур жоншны орд ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хамаарах дагаж мөрдөх хууль дүрэм журам заавруудын нэр томьёог хавсаргав. Монгол улсын хуулиуд

- Агаарын тухай
- Ариун цэврийн тухай
- Байгаль орчныг хамгаалах тухай
- Газрын тухай
- Галын аюулгүй байдлын тухай
- Химиин хорт болон аюултай бодисын тухай
- Усны тухай
- Ургамал хамгааллын тухай
- Ой хээрийг түймрээс хамгаалах тухай
- Хог хаягдалын тухай

Стандартууд

- Байгаль орчныг хамгаалах стандартын систем Үндсэн дүрэм MNS 17,00,06-79
- Агаар орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS 4585-98
- Агаарын чанарын стандарт MNS 4585 /2007
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.MNS 5010:2001
- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 0 900-92
- БОХ. Ус ашиглалт, хамгаалалт MNS 17,1,1,10-79
- БОХ. Усан мандал. Ус ашиглалтын ангилал MNS 17,1,1,14-80
- БОХ. Усан мандал. Газрын доорхи усыг Бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага MNS 33,42-82
- Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS 4586:98
- Усны чанар хаягдал бохир ус MNS 4943:2000
- Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 900-92
- Усны чанар MNS, ISO 6107-1:2002

- БОХ. Газар. Газар эдэлбэр. Газар ашиглалт MNS 3473-83
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS5917:2008
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5915:2008
- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS5918:2008
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 4915:2000
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт. Техникийн шаардлага MNS 4917:2000
- Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага MNS 4920:2000
- БОХ. Сэргээн сайжруулах эвдэрсэн газрын ангилал MNS 17,5,1,18-83
- Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага MNS 3298-90
- Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлт MNS 3297-91
- Хот суурин газрын хөрсний ариунцэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
- БОХ. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэг төрөл MNS 39,85-87
- БОХ. Хөрс. Хот суурин газрын хөрсний үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 32,97-91

Засгийн газрын тогтоол

- Төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай. Засгийн газрын 1995 оны 154-р тогтоол
- Усны үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 1999 оны 43-р тогтоол
- Байгаль орчныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1995 оны 151-р тогтоол
- Агаар хамгаалах хөтөлбөр. Засгийн газрын 1999 оны 82-р тогтоол
 - Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх тухай. Засгийн газрын 1997 оны 152-р тогтоол



СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

7 давхарт, DG TOWER, Балдан-Осорын гудамж, 7-р
баг, Баруун-Урт сум, 22075, Утас: (70518892)

Утас: 70518891 Факс: 70518891

Цахим шуудан: baigaliorchin@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: www.baigalorhin.su.gov.mn

2024.09.17 № 255

танай 2024.09.17 -ны № 112 -т

Г


АДАЭ ХХК -НД

Г

Г Санаал хүргүүлэх тухай Г

Эрдэнэцагаан сумын нутагт ашигт малтмалын ашиглалтын MV-020796 тусгай зөвшөөрөлтэй "Эрдэнэцагаан" нэртэй талбайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд нь Онгон, Баяндэлгэр сумдын нутаг дах Онгон таван буллаг нэрээр байглийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулах.

Мөн Монгол Улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд нарын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нөхөн сэргээлтийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах 167, A/698, A/336, A/242 хамтарсан тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Чиглэл хүргүүлэх тухай" 2020 оны 12 дугаар сарын 22-ны 01/8786 тоот албан бичигт заасны дагуу Хонхор цантын нүхт нэртэй 111° 51' 57.6" 45° 48' 25.6" солбилцолд орших газарт нөхөн сэргээлт, хаалт хамгаалалт хийж хэрэгжүүлэн ажиллах саналыг хүргүүлж байна.



Сүхбаатар аймгийн байгаль орчин, аялал
жуулчлалын газар
Захиргаа
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Шархүү Нямхүү
2024-09-17 15:26:09

“АДАЭ” ХХК

Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг;
15-р хороо, Режис плейс барилга, 602 тоот.
Утас/Факс: +976-88105930
E-mail: adae.company1@gmail.com

БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХМӨНХ ТАНАА

2024 он 09 сар 24 одор № 124

Хүснэгт гаргах нь:

Манай компани нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших “Булаг” нэртэй ашигт малтмалын ашиглалтын MV-020796 дугаартай тусгай зөвшөөрлийг эзэмшидэг.

2019 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг боловсруулан батлуулж байсан.

Мөн 2019 оны сүүлээс Коронавиуст халдварт /КОВИД-19/-ын цар тахал дэлхийн олон улсад тархаж эхэлсэнээс хойш тус компани нь 2023 он хүртэл үйл ажиллагааг огт явуулаагүй бөгөөд, энэ тухай албан тодорхойлолт, **Х тайланг** Ашигт малтмал газрын тосны газар, Татварын газар зэрэг холбогдох төрийн захиргааны байгууллагад хуулийн хугацаанд гарган илгээж байсан болно.

Цаашид бид хөрөнгө оруулалтын асуудлаа шийдвэрлэж энэ оны 4 дүгээр улиралд багтаан уурхайн ажил эхлүүлэх төлөвлөгөөтэйгээр бэлтгэл ажлуудыг хангаж холбогдох эрх зүйн баримт бичгийг бүрдүүлэн ажиллаж байна.

Иймд БОНУ-ний тайланг эхний жилээр тооцон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан өгч бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Г.ЦЭНД